



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/504


Хэрлэн сум

С.Энхмаад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 зүйлийн 24.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 5 дугаар багийн иргэн Сагадай овогтой Энхмаа нь “Авъяаслаг Монголчууд” шоуны шилдэг 32-т шалгарч, 2 дугаар шатанд оролцоход шаардагдах тайзны жижиг хэрэглэл, хувцас оёулахад нь зориулж 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийн шийдвэрлэх зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ